



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 11 сарын 20 өдөр

Дугаар А/409

Сүхбаатар сум

Сайхан сумын төрийн өмчийн ерөнхий  
боловсролын 2 дугаар сургуульд  
тусгай зөвшөөрөл олгох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5."а", "Аж ахуй үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай" хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.4, Боловсролын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 23 дугаар зүйлийн 23.1, 30 дугаар зүйлийн 30.1.6, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2010 оны 353 дугаар тушаалаар батлагдсан "Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичигт тавигдах шаардлага"-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сайхан сумын Хөтөл 1 дүгээр багт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 480 хүүхдийн хүчин чадалтай ерөнхий боловсролын сургууль шинээр ашиглалтад орсонтой холбогдуулан тус суманд төрийн өмчийн 2 дугаар сургуулийг шинээр байгуулж, сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаатай олгосугай.

2. Сайхан сумын төрийн өмчийн Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийг улсын бүртгэлд бүртгэн гэрчилгээ олгохыг аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга /Б.Саранчимэг/-т үүрэг болгосугай.

3. Сайхан сумын төрийн өмчийн Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн сургалтын үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга /Б.Энхбат/, Боловсрол, соёл урлагийн газрын дарга /Ч.Жаргалсайхан/, сумын Засаг дарга /О.Буянаа/ нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ

Alban bichig Zahiramj